

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Огноо: 2020.04.25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/4/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Аудитор Э.Бүгүнүтэй

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс	1	1				1			
ДҮН		1	1				1			

Гурав. Аудитын үр дүн

3.1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Д/д	Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн нэр	Алдаа, зөрчлийн дүн		Зөвлөмж	Төлбөр-ийн акт	Үүнээс	
						Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
A	1	2	3	4	5	6	7
1	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс	3	11,906.9	1	-	2	-
Дүн		3	11.906,9	1	-	2	-

3.2 . Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлбэл:

Алдаа, зөрчилтэй асуудал 1.

Тайлант онд 4 байгууллагатай нийт 19.5 сая төгрөгийн ажил гүйцэтгэх шууд гэрээ байгуулсан боловч гэрээний хэрэгжилт, үүргийн биелэлтийг дүгнээгүй байна. Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Алдаа, зөрчилтэй асуудал 2.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 195 мэдээллээс 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 21 мэдээллийг байршуулаагүй, мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 11,885.3 сая төгрөгийн 51 ажил гүйлгээг байршуулаагүй байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.10”-д “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т “төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа, ажил үйлчилгээнд олон нийтийн хяналт тавих боломжоор хангах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Алдаа, зөрчилтэй асуудал 3.

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлаас хэлмэгдэгсдийн өдрийн арга хэмжээнд 2.1 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан нь “Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтийн дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу эдийн засгийн ангиллын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН
КОМИССЫН ДАРГА С.ОДОНТУЯА
ТАНАА

2021.04.26 № 1313
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ